



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хайлааст голомт ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СБА-2024/02/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn
Баруун-Урт хот
2023 он

Дарга,
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа
Утас: 70518396
Аудитын менежер: Г.Даваа
Утас: 70512123
Аудитор: О.Барчидгүнсэн
Утас: 70512123

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

ХАЙЛААСТ ГОЛОМТ ОНӨААТҮГ
ДАРГА С.ЛХАГВАДОРЖ ТАНАА

2024.03.15 № 228
танай _____ - ны№ _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хайлааст Голомт ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Хайлааст голомт ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 дүгээр тогтоолоор байгууллагын дүрэмд, Сүхбаатар аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2023 оны А/19 тоот тогтоолоор бүтээгдэхүүний үнэ тарифт тус тус өөрчлөлт оруулсан байна.

Аудитын гол асуудал

Хайлааст Голомт ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлангаар Сумын ИТХ-ын 2023 оны А/03 тогтоолоор 1,759,245.1 мянган төгрөгийн цэвэр, бохир усны шугам, барилга байгууламж шинээр ашиглалтад орж, үйл ажиллагааг эхлүүлсэн боловч төлбөрт үйлчилгээний төлбөрийн үнэ тарифыг мэргэжлийн байгууллагаар тогтоолгоогүйгээс орлогыг дутуу төвлөрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Хайлааст Голомт ОНӨААТҮГ газар нь 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлуулжээ. Сүхбаатар сумын Засаг даргатай гэрээ байгуулж, гүйцэтгэлийг үнэлээгүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



ДАВАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	175,842,927.13	78,815,779.07
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	71,947,457.26	14,062,265.75
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	71,947,457.26	14,062,265.75
33	АВЛАГА	41,178,402.20	43,401,815.92
33500	Бусад авлага	22,382,952.55	14,538,962.55
34	УРЬДЧИЛГАА	84,259.02	84,259.02
35	БАРАА МАТЕРИАЛ	62,632,808.65	21,267,438.38
35400	Хангамжийн материал	62,632,808.65	21,267,438.38
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,614,057,535.62	3,213,586,102.16
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,614,057,535.62	3,213,586,102.16
39200	Биет хөрөнгө	1,592,878,335.62	3,192,406,902.16
39300	Биет бус хөрөнгө	21,179,200.00	21,179,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,789,900,462.75	3,292,401,881.23
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,273,170,959.72	2,846,238,330.18
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,273,170,959.72	2,846,238,330.18
41300	Өглөг	16,752,354.92	47,131,473.08
41360	Бусад өглөг	16,752,354.92	47,131,473.08
41400	Урьдчилж орсон орлого	1,256,418,604.80	2,799,106,857.10
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	516,729,503.03	446,163,551.05
51	Засгийн газрын хувь оролцоо	516,729,503.03	446,163,551.05
51200	Хуримтлагдсан үр дүн	-92,994,026.97	-163,559,978.95
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	50,346,312.00	50,346,312.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,789,900,462.75	3,292,401,881.23

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	108,393,021.27	151,522,460.11
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	108,393,021.27	151,522,460.11
120	Нийтлэг татварын бус орлого	108,393,021.27	151,522,460.11
120009	Бусад орлого	128,561,422.56	288,655,602.20
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	262,336,214.91	266,276,720.00
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	287,116,557.30	409,145,497.13
120012	Эрхийн шимтгэлийн орлого /ТӨҮГ/	4,611,941.10	5,735,635.04
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	105,800,313.05	215,120,473.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	105,800,313.05	215,120,473.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	105,800,313.05	215,120,473.84
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	105,800,313.05	215,120,473.84
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	104,880,488.82	212,599,114.52
210812	Санхүүгийн зардал /ТӨҮГ/	458,630.12	1,947,795.82
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	461,194.11	573,563.50
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,592,708.22	-63,598,013.73

VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	2,592,708.22	-63,598,013.73
----	---	--------------	----------------

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	559,377,218.00	50,346,312.00	-95,586,735.19	514,136,794.81
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	559,377,218.00	50,346,312.00	-95,586,735.19	514,136,794.81
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	2,592,708.22	2,592,708.22
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	559,377,218.00	50,346,312.00	-92,994,026.97	516,729,503.03
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	559,377,218.00	50,346,312.00	-92,994,026.97	516,729,503.03
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	-6,967,938.25	-6,967,938.25
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	559,377,218.00	50,346,312.00	-99,961,965.22	509,761,564.78
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-63,598,013.73	-63,598,013.73
20	2023 оны 12-р сарын 30-наарх үлдэгдэл	559,377,218.00	50,346,312.00	-163,559,978.95	446,163,551.05

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	347,592,095.06	367,925,476.22
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	347,592,095.06	367,925,476.22
120	Нийтлэг татварын бус орлого	347,592,095.06	367,925,476.22
120009	Бусад орлого	0	78,317,511.60
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	347,592,095.06	289,607,964.62
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	356,665,781.32	393,217,773.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	356,665,781.32	393,217,773.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	356,665,781.32	393,217,773.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	70,467,303.80	147,722,991.35
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	70,467,303.80	147,722,991.35
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,265,309.50	51,290,053.73
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	31,265,309.50	51,290,053.73
2104	Хангамж, бараа материалын зардал	172,630,872.80	88,573,040.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	75,957,568.17	18,486,910.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	96,673,304.63	70,086,130.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	82,302,295.22	105,631,688.19
210815	Хүүний төлбөр төлсөн /ТӨҮГ/	458,630.12	1,947,795.82
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	25,262,375.46	28,914,567.62
210817	Даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	23,041,346.78	47,096,285.23
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	33,539,942.86	27,673,039.52
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-9,073,686.26	-25,292,297.05
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	5,744,546.99	5,162,071.54

140003	Бусдад олгосон зээл болон урьдчилгааны эргэн төлөлт	1,593,800.00	0
140007	Хүлээн авсан хүүний орлого	4,150,746.99	5,162,071.54
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	3,180,000.00	3,029,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,180,000.00	3,029,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,180,000.00	3,029,000.00
225104	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	3,180,000.00	3,029,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	2,564,546.99	2,133,071.54
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0	-34,725,966.00
14	Бусад эх үүсвэр	0	44,000,000.00
145007	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0	44,000,000.00
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0	78,725,966.00
250002	Зээл, өрийн үнэт цаасны төлбөр төлсөн мөнгө	0	78,725,966.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-6,509,139.27	-57,885,191.51
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	78,456,596.53	71,947,457.26
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	71,947,457.26	14,062,265.75

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

д/д	Үзүүлэлт	хэмжих нэгж	2022оны Гүйцэтгэл.	2023 он төлөвлөгөө	2023 оны Гүйцэтгэл
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	гкал	3.50	3.50	3.50
2	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн тоо		80.00	89.00	89.00
	-айл өрхийн тоо	ш	50.00	59.00	59.00
	-Албан байгууллагын тоо	ш	30.00	30.00	30.00
3	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн үнэ	төг	1,250.00	1,900.00	1,900.00
4	Нийт орлого	мян.төг	347,592.00	347,592.00	367,925.00
	цэвэр борлуулалт	мян.төг	347,592.00	347,592.00	289,607.90
	Бусад орлого				78,317.10
5	Нийт зардал	мян.төг	356,665.70	356,665.70	430,949.40
	Үүнээс: удирдлагын зардал	мян.төг	101,273.70	119,736.80	119,736.80
6	Татварын өмнөх ашиг	мян.төг	3,053.90	3,053.90	(63,024.4)
7	Цэвэр ашиг (алдагдал)	мян.төг	(24,780.30)	(24,780.30)	(63,024.40)
8	Төсвийн төлбөр		1,920.00	1,920.00	2,100.00
9	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	мян.төг	1.10	1.10	0.90
10	Нийт авлага	мян.төг	41,178.40	41,178.40	43,401.80
11	Нийт өглөг	мян.төг	30,379.10	30,379.10	47,131.40
	Богино хугацаат өр төлбөр	мян.төг	30,379.10	30,379.10	47,131.40
12	Хөрөнгө оруулалт, их засвар ТЗБАХ	мян.төг	19,080.00	4,100.00	15,000.00
13	Ажиллагсадын тоо	мян.төг	14.00	16.00	16.00
14	Цалингийн сан	мян.төг	70467.3	127299.9	147722.9
15	Нийт хөрөнгийн дүн	мян.төг	1,614,057.50	1,614,057.50	3,192,406.90
16	-эргэлтийн хөрөнгө	мян.төг	175,842.90	175,842.90	78,815.70
	үүнээс бараа материал	мян.төг	62,632.80	62,632.80	21,267.40
17	-үндсэн хөрөнгө	мян.төг	2628232.07	262832.07	2629082.07

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хайлааст Голомт ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Барчидгүнсэн, гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Нарантуяа, дарга, тэргүүлэх аудитор Г.Даваа нар тус тус хэрэгжүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлаас 319,819.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 4,797.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1¹-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд уг зардлууд 57,470.6 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь өмнөх онд дулаан үйлдвэрлэлтэй холбоотой зардал бүртгэснийг тайлант онд залруулж бүртгэсэн нөлөөлжээ.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны цахим системд тайлант оны өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэрийг мэдээлжээ.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн боловч өр төлбөр авлагатай албан шаардлагын биелэлт 87.0 хувьтай байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	4	61,282.5	4	45,367.8	87
Зөвлөмж	2	-	2	-	100
Нийт дүн	2	0	2	-	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нүүрс тээврийн хөлс, нүүрсний зарцуулалт болон цэвэр бохир усанд холбогдсон байгууллагын орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэхийг нарийвчилж үзэхээр төлөвлөв.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 90,533.2 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд албан шаардлага хүргүүллээ.

5.1 Албан шаардлага

Санхүүгийн тайлангаар авлага 43,401.8 мянга, өр төлбөр 47,131.4 мянга нийт 90,533.2 мянган болж өмнөх оноос авлага, өглөг өссөн байна.

¹ байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5./дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах/, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5 /хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх/ заалттай нийцэхгүй байна.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

5.2.2 Илрүүлэлт:

Байгууллагын бүртгэлд байгаа авто тээврийн хэрэгсэлд бусад тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглээгүй байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ" заасныг хэрэгжүүлээгүй байна.

Зөвлөмж : Авто тээврийн хэрэгсэлд тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэх

Тээвэр, шатахууны зардалтай холбоотой асуудал

5.3.3 Илрүүлэлт:

Албан ажлын автомашинуудад мэдээлэл, хяналтын төхөөрөмж буюу GPS суурилуулаагүй нь Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, сангийн сайдын 2022.12.23-ны өдрийн 95/260 дугаартай хамтарсан тушаалаар батлагдсан "Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам"-ын 4.2 дахь "Алба ажлын автомашин нь Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598 стандартын шаардлагыг хангасан байна." заалт, Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598 стандартын 8.4.3, 11.1 дэх заалттай нийцэхгүй байна. Албан ажлын автомашинуудад GPS суурилуулаагүй нь шатахууны зардалд хэмнэлт бий болохгүй байх сөрөг үр дагавартай байна.

Өгсөн зөвлөмж:

Албан ажлын автомашинуудад MNS 4598 стандартад заасан мэдээлэл, хяналтын төхөөрөмж буюу GPS суурилуулж, жолоочийн тооцооны хуудаст автомашины явсан маршрутыг жолоочоор GPS-ийн мэдээлэлд үндэслэн дэлгэрэнгүй бичүүлж, хяналт тавьж, шатахууны зардалд хэмнэлт бий болгож ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Авто тээврийн хэрэгсэлд тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэх	1	0					1	0				
Дүн	1	0					1	0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган

төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Санхүүгийн тайлангаар авлага 43,401.8 мянга, ер төлбөр 47,131.4 мянга нийт 90,533.2 мянган төгрөгийг болж өмнөх оноос авлага, өглөг өссөн байна	1	90,533.2	1	90,533.2		
Албан ажлын автомашинуудад мэдээлэл, хяналтын төхөөрөмж буюу GPS суурилуулаагүй байна.	1	0			1	0